



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 29

Бор-Өндөр

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГЛЭЛИЙГ
ӨӨРЧЛӨХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Холбоо 2 дугаар багийн 49 дүгээр байрны замын хөдөлгөөний чиглэл, зураглалыг 01 дүгээр хавсралтаар, Зах худалдааны төвийн замын хөдөлгөөний чиглэл, зураглалыг 02 дугаар хавсралтаар өөрчлөн баталсугай.
2. Замын хөдөлгөөний чиглэлийг өөрчилсөн талаар ард иргэдэд мэдээлж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг дарга П.Чинбат, Цагдаагийн хэлтсийн дарга, дэд хурандаа Т.Энхбаярт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, үйлдвэрлэл дэд бүтцийн хороон дарга Э.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ